



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦАГААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 19 өдөр

Дугаар А/72

Цагаан-Уул сум

Г Хөрөнгө зарцуулах тухай Г


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Аймгийн хурц арслан Б.Баттогтохын нэрэмжит Аймаг цэргийн цолтой 256 бөхийн барилдааныг Улаанбаатар хотод бөхийн өргөөнд зохион байгуулахад зориулж 15.000.000 (Арван таван сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Бөхийн барилдааны 15.000.000 төгрөгийг Засаг даргын Тамгын газрын сум орон нутгийг сурталчилах хөтөлбөр арга хэмжээний зардлаас гаргаж зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Оюунчимэг) нарт зөвшөөрсүгэй.

3. Нягтлан бодох бүртгэлийн хууль журмын дагуу санхүүгийн баримтыг бүрдүүлж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын нярав (Н.Алтангэрэл)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.ГОНЧИГНЯМ